

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/65/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаангом хот
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Ахлах аудитор: Т.Намжил
Утас: 70453721, Цахим хаяг: NamjilT@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

ӨМНӨГОВЬ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.БОЛОРМАА ТАНАА

2022.02.15 № УВА-2020/05/НА-СТА-ТЧЗ
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өмнөговь сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө” гэж заасныг зөрчин Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа Орлогын голын гүүрийн засварын санхүүжилт 103,785.1 мянган төгрөгийг гэрээний дагуу гүйцэтгэгч компанид олгосныг шууд зардалд бүртгэжээ. Энэ нь тухайн онд олгох нийт санхүүжилтийн зарим хэсгийг аймгийн хөрөнгө оруулалтын данснаас сумын Засаг даргын тамгын газрын дансаар дамжуулахгүйгээр гүйцэтгэгчид шууд шилжүүлсэнтэй холбоотой байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

0200200289

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Дүгнэлтийн үндэслэл	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	3
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	3
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НА	Нийцлийн аудит

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	113,594,072.59	274,584,195.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	11,959,097.59	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,466,705.00	-
335	Бусад авлага	10,492,392.59	-
3351	Байгууллагаас авах авлага	10,492,392.59	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	101,634,975.00	274,584,195.00
351	Түүхий эд материал	-	-
354	Хангамжийн материал	101,634,975.00	262,839,529.00
35410	Бичиг хэргийн материал	2,453,670.00	2,018,550.00
35420	Аж ахуйн материал	29,176,505.00	40,783,323.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,770,000.00	1,770,000.00
35440	Түлш, шатах тослох материал	-	-
35450	Барилгын засварын материал	-	-
35460	Хүнсний материал	-	-
35470	Бусад хангамжийн материал	68,234,800.00	218,267,656.00
35600	Мал амьтад	-	11,744,666.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,720,785,316.32	4,693,195,659.70
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,720,785,316.32	4,693,195,659.70
391	Газар	-	-
392	Биет хөрөнгө	4,672,459,316.32	4,640,829,659.74
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,089,780,805.68	1,187,157,668.68
39202	Хуримтлагдсан элэгдэл	(201,374,428.85)	(262,506,314.65)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	82,288,500.00	89,288,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(53,549,666.53)	67,768,735.81)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	210,039,852.19	233,799,668.56
39206	Хуримтлагдсан элэгдэл	(94,730,468.26)	(106,835,722.35)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	63,543,040.97	64,539,186.97
39208	Хуримтлагдсан элэгдэл	(40,542,920.87)	(45,849,997.23)
39209	Зам, гүүрийн байгууламж	3,519,606,700.00	3,519,606,700.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(245,878,476.12)	(382,864,691.28)
39214	Бусад үндсэн хөрөнгө	382,502,346.50	462,930,675.62
39215	Хуримтлагдсан элэгдэл	(154,225,968.39)	(165,667,278.77)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	115,000,000.00	115,000,000.00
39217	Ном	-	-
393	Биет бус хөрөнгө	48,326,000.00	52,365,999.96
39301	Програм хангамж	2,772,000.00	2,772,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,972,000.00)	(2,172,000.04)
39303	Бусад биет бус хөрөнгө	53,726,000.00	57,966,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(6,200,000.00)	(6,200,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,834,379,388.91	4,967,779,854.70
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,060,400.00	1,745,500.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,060,400.00	1,745,500.00
411	Богино хугацаат үнэт цаас	2,060,400.00	1,745,500.00
413	Өглөг	2,060,400.00	1,745,500.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	1,169,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	2,060,400.00	575,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,832,318,988.91	4,966,034,354.70
51	Засгийн газрын хувь оролцоо	4,832,318,988.91	4,966,034,354.70
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	613,463,617.77	653,885,617.77
51101	Өмч: - төрийн	613,463,617.77	653,885,617.77
512	Хуримтлагдсан үр дүн	3,920,065,668.44	4,013,640,235.05
51210	Өмнөх үеийн үр дүн	3,920,065,668.44	3,900,285,763.35

51220	Тайлант үеийн үр дүн	-	113,354,471.70
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	298,789,702.70	298,508,501.88
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,834,379,388.91	4,967,779,854.70

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,313,232,054.00	1,043,535,184.72
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,849,690,651.00	462,409,849.72
120	Нийтлэг татварын бус орлого	1,849,690,651.00	462,409,849.72
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,849,690,651.00	462,409,849.72
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	463,541,403.00	581,125,335.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,369,503.00	112,847,135.00
	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	2,900,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	450,000.00	106,507,135.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,019,503.00	6,340,000.00
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	450,171,900.00	468,278,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	450,171,900.00	468,278,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	703,259,778.78	928,943,125.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	703,259,775.78	825,157,990.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	667,897,642.54	786,139,712.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	269,308,082.70	288,710,742.91
210101	Үндсэн цалин	220,891,539.00	217,489,998.62
210102	Нэмэгдэл	434,700.00	45,810,083.99
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал		1,587,535.00
210105	Гэрээт ажлын хөлс	47,981,843.70	23,823,125.30
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,769,916.80	34,621,842.90
210201	Тэтгэврийн даатгал	24,204,819.50	24,901,630.56
210202	Тэтгэмжийн даатгал	2,649,530.42	2,921,872.45
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,114,921.19	2,330,778.94
210204	Ажилгүйдлийн даатгал	438,097.53	429,302.79
210205	Эрүүл мэндийн даатгал	4,362,548.16	4,038,258.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,735,521.06	35,068,801.01
210301	Гэрэл, цахилгаан	5,428,721.06	5,779,275.01
210302	Түлш, халаалт	28,306,800.00	29,289,526.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,938,162.00	22,284,968.00
210401	Бичиг хэрэг	2,685,700.00	3,619,920.00
210402	Тээвэр, шатахуун	18,345,479.00	14,762,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,712,883.00	2,420,131.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,194,100.00	11,317,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,652,000.00	11,317,400.00
210604	Урсгал засвар	5,652,000.00	11,317,400.00
2107	Томилолт, зочны зардал	2,708,000.00	4,930,000.00

210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	2,708,000.00	4,930,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,255,360.00	5,528,902.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		4,064,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	403,200.00	403,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	77,200.00	213,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	106,471.00	106,471.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	198,000.00	249,000.00
210807	Газрын төлбөр	448,489.00	404,881.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	295,530,599.98	383,677,056.01
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,977,100.00	123,450,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	899,000.00	2,603,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	256,654,499.98	257,622,756.01
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,362,133.24	39,018,277.77
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,913,400.00	23,539,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,653,400.00	20,921,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,260,000.00	2,617,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	17,548,733.24	10,636,877.77
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,548,733.24	10,636,877.77
213404	Хөрөнгийн		
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,900,000.00	4,842,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,900,000.00	4,842,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		103,785,135.00
2200	Дотоод эх үүсвэрээр		103,785,135.00
223001	Бусад хөрөнгө		103,785,135.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>1,609,972,278.22</u>	<u>114,592,059.12</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,690,959,859.76	1,237,587.42
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	6,695,699.01	1,237,587.42
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	1,684,264,160.75	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,690,959,859.76)	(1,237,587.42)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(80,987,581.54)</u>	<u>113,354,471.70</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>463,541,403.00</u>	<u>581,125,335.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	463,541,403.00	581,125,335.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,369,503.00	112,847,135.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,900,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	450,000.00	106,507,135.00

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,019,503.00	6,340,000.00
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	450,171,900.00	468,278,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	450,171,900.00	468,278,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	463,541,403.00	477,340,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	463,541,403.00	477,340,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	428,179,269.76	438,106,722.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	270,654,372.70	287,244,037.91
210101	Үндсэн цалин	222,237,829.00	216,091,973.62
210102	Нэмэгдэл	434,700.00	45,810,083.99
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал		1,587,535.00
210105	Гэрээт ажлын хөлс	47,981,843.70	23,754,445.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,743,246.00	34,608,650.31
210201	Тэтгэврийн даатгал	24,154,955.65	24,585,065.74
210202	Тэтгэмжийн даатгал	2,649,529.26	2,891,872.45
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,119,623.39	2,315,080.94
210204	Ажилгүйдлийн даатгал	438,103.44	439,302.79
210205	Эрүүл мэндийн даатгал	4,381,034.26	4,377,328.39
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,735,521.06	35,068,801.01
210301	Гэрэл, цахилгаан	5,428,721.06	5,779,275.01
210302	Түлш, халаалт	28,306,800.00	29,289,526.00
210303	Цэвэр, бохир ус		
2104	Хангамж, бараа материалын зардал	30,566,962.00	21,187,131.00
210401	Бичиг хэрэг	3,450,200.00	3,113,800.00
210402	Тээвэр, шатахуун	18,245,479.00	14,013,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,712,783.00	2,420,131.00
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,158,500.00	1,439,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,916,500.00	3,112,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,844,500.00	
210602	Тавилга	4,500,000.00	
210604	Урсгал засвар	6,572,000.00	3,112,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,878,000.00	4,354,300.00
210702	Дотоод албан томилолт	2,878,000.00	4,354,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,320,568.00	5,728,902.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		4,264,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	403,200.00	403,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	77,200.00	213,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	106,471.00	106,471.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	88,000.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	198,000.00	249,000.00
210807	Газрын төлбөр	513,697.00	404,881.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,364,100.00	46,802,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	41,465,100.00	43,587,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	899,000.00	3,215,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,362,133.24	39,233,477.77
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,913,400.00	23,754,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,653,400.00	20,921,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,260,000.00	2,833,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	17,548,733.24	10,636,877.77
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,548,733.24	10,636,877.77
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,900,000.00	4,842,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,900,000.00	4,842,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)		
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		<u>103,785,135.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		103,785,135.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		103,785,135.00
2200	Дотоод эх үүсвэрээр		103,785,135.00
223001	Бусад хөрөнгө		103,785,135.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	613,463,617.77	300,056,266.79	3,999,069,485.89		4,912,589,370.45
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	613,463,617.77	300,056,266.79	3,999,069,485.89		4,912,589,370.45
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-

C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн			(80,987,581.54)		(80,987,581.54)
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	613,463,617.77	298,789,702.70	3,920,065,668.44		4,832,318,988.91
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	613,463,617.77	298,789,702.70	3,920,065,668.44		4,832,318,988.91
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	20,061,105.91		(19,779,905.09)		281,200.82
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	633,524,723.68	298,789,702.70	3,900,285,763.35		4,832,600,189.73
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(281,200.82)	-	-	40,422,000.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	40,422,000.00	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-		113,354,471.70		113,354,471.70
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	653,885,617.77	298,508,501.88	4,013,640,235.05		4,966,034,354.70

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ЭЗА	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	469,778,200.00	457,641,322.23	12,136,877.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	469,778,200.00	457,641,322.23	12,136,877.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	469,778,200.00	457,641,322.23	12,136,877.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	290,984,100.00	287,244,037.91	3,740,062.09

210101	Үндсэн цалин	265,784,100.00	216,091,973.62	49,692,126.38
210102	Нэмэгдэл		45,810,083.99	(45,810,083.99)
210103	Унаа хоолны хөнгөлөлт			
210104	Урамшуулал		1,587,535.00	(1,587,535.00)
210105	Гэрээт ажлын хөлс	25,200,000.00	23,754,445.30	1,445,554.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,373,100.00	34,608,650.31	1,764,449.69
210201	Тэтгэврийн даатгал	24,733,600.00	24,585,065.74	148,534.26
210202	Тэтгэмжийн даатгал	2,909,900.00	2,891,872.45	18,027.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,328,000.00	2,315,080.45	12,919.06
210204	Ажилгүйдлийн даатгал	581,900.00	439,302.79	142,597.21
210205	Эрүүл мэндийн даатгал	5,819,700.00	4,377,328.39	1,442,371.61
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,808,500.00	35,068,801.01	739,698.99
210301	Гэрэл, цахилгаан	6,509,000.00	5,779,275.01	729,724.99
210302	Түлш, халаалт	29,299,500.00	29,289,526.00	9,974.00
210303	Цэвэр, бохир ус			
210304	Байрны түрээс			
2104	Хангамж, бараа материалын зардал	20,425,800.00	20,067,131.00	358,669.00
210401	Бичиг хэрэг	3,084,400.00	3,113,800.00	(29,400.00)
210402	Тээвэр, шатахуун	11,728,500.00	12,893,800.00	(1,165,300.00)
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,972,700.00	2,420,131.00	1,552,569.00
210404	Ном, хэвлэл			
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200,000.00	200,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,440,200.00	1,439,400.00	800.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал			
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,613,500.00	1,612,000.00	1,500.00
210604	Урсгал засвар	1,613,500.00	1,612,000.00	1,500.00
2107	Томилолт, зочны зардал	4,366,600.00	4,354,300.00	12,300.00
210701	Гадаад албан томилолт			
210702	Дотоод албан томилолт	4,366,600.00	4,354,300.00	12,300.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах			
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,635,500.00	5,728,902.00	4,906,598.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,950,000.00	4,264,000.00	4,686,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	403,200.00	403,200.00	
210803	Даатгалын үйлчилгээ	232,500.00	213,350.00	19,150.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	147,000.00	106,471.00	40,529.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	102,500.00	88,000.00	14,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	249,900.00	249,000.00	900.00
210807	Газрын төлбөр	550,400.00	404,881.00	145,519.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,816,500.00	45,202,900.00	613,600.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	42,600,000.00	41,987,300.00	612,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,216,500.00	3,215,600.00	900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,754,600.00	23,754,600.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,754,600.00	23,754,600.00	
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	20,921,600.00	20,921,600.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,833,000.00	2,833,000.00	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	469,778,200.00	457,641,322.23	12,136,877.77
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	468,278,200.00	457,641,322.23	
132001	Орон нутгийн төсвөөс			
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих			
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,500,000.00		1,500,000.00
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих			
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО			
610001	Төсвийн байгууллага	1	1	
610002	Төсвөөс гадуур байгууллага			
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	29	28	
620001	Удирдах ажилтан	8	8	
620002	Гүйцэтгэх ажилтан	10	9	
620003	Үйлчлэх ажилтан	3	3	
620004	Гэрээт ажилтан	8	8	

2.6 Аудит хийсэн нэмэлтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		108,005,135.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ		4,220,000.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		4,220,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал		1,120,000.00	
210401	Бичиг хэрэг		00.00	
210402	Тээвэр, шатахуун		1,120,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		1,500,000.00	
210604	Урсгал засвар		1,500,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	1,600,000.00	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		1,600,000.00	

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		103,785,135.00
2200	Дотоод эх үүсвэрээр		103,785,135.00
223001	Бусад хөрөнгө		103,785,135.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	112,847,135.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		112,847,135.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		106,507,135.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		6,340,000.00
131106	Төсвийн урамшуулал		00.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Орон нутгийн удирдлагыг мэдээлэл, бодлогын удирдамжаар ханган хууль тогтоомж, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулан сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангаж, төрийн үйлчилгээг иргэдэд ил тод нээлттэй, чанар, хүртээмжтэй хүргэх зорилготой байгууллага юм.

Тамгын газрын чиг үүргийн хувьд орон нутагт төрийн захиргааны удирдлага, төлөвлөлт санхүү, эдийн засгийн бодлого, нийгмийн бодлогын асуудлыг хариуцан төрийн хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, түүний хэрэгжилтийг хангуулах төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг хуулийн дагуу түргэн шуурхай, чанартай хүргэх, иргэдийн ажиллаж амьдрах таатай орчин бүрдүүлэхэд гол анхаарал хандуулан ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, төсвийн тухай хууль, бусад хууль, тогтоомжуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль - 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ. Тайлант онд дотоод аудит хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Өмнөговь сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн бөгөөд байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн Өмнөговь сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэлээ.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн аливаа бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 133,400.4 мянган төгрөгөөр буюу 2.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	11,959.1		-11,959.1
Бараа материал	101,635.0	274,584.2	172,949.2
Үндсэн хөрөнгө	4,720,785.3	4,693,195.6	-27,589.7
Нийт хөрөнгө	4,834,379.4	4,967,779.8	133,400.4
Өр төлбөр	2,060.4	1,745.5	-314.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,832,319.0	4,966,034.3	133,715.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,834,379.4	4,967,779.8	133400.4

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 11,959.1 мянган төгрөгөөр буурсан нь зураг төсвийн авлага барагдсантай холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 274,584.2 мянган төгрөг болж 172,949.2 мянган төгрөгөөр өссөнд Орлогын голын гүүрийн ажил дуусаагүй байгаа тул бусад бараа материал дансанд бүртгэсэн болон ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар нэмэгдсэн материалтай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,967,779.8 мянган төгрөг болж 27,589.7 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгө акталсан болон элэгдлийн зардлаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь 250,368.0 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан болон балансаас балансад шилжүүлэн авсан хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 36,566.9 мянган төгрөгийн акталсан үндсэн хөрөнгө, 257,622.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаар буурсан байна.

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 1,745.5 мянган төгрөг болж 314.9 мянган төгрөгөөр буурсан нь албан томилолтын болон тээвэр шатахууны өр буурсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,966,034.3 мянган төгрөг болж 133,715.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Энэ нь хөрөнгө өссөнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон төсвөөс 371,336.7 мянга, давсан орлогоос 55,000.0 мянга, нийт 426,336.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 426,336.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 15,806.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 442,143.2 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь тээвэр шатахуун, бараа үйлчилгээний бусад зардлыг нэмэгдүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 27,635.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр 468,278.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,500.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос, нийт 469,778.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон төсвөөс 468,278.2 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 457,641.3 мянган төгрөг буюу 97.7 хувьтай байгаа нь үндсэн дансны хэмнэгдэл байна. Үндсэн данснаас 10,636.9 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагаа	233,143.6	227,394.6	5,749.0	97.5
2	Баг хорооны үйл ажиллагаа	88,772.8	85,986.5	2,786.3	96.8
3	Төрийн өмчит барилгын тогтомол зардал	35,753.8	35,430.8	323.0	99
4	Нийтлэг үйлчилгээ	45,303.4	42,687.5	2,615.9	94.2
5	Мэдээлэл сурталчилгаа	250.0	200.0	50.0	80
6	Ажил олгогчоос олгох тэтгэмж	2,833.0	2,833.0		100
7	Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн тэтгэмж	20,921.6	20,921.6		100
8	Орон нутгийн нөөц хөрөнгө	29,500.0	29,432.8	67.2	99.8
9	Мал тооллого	1,500.0	1,500.0		100
10	Байгаль орчноос хамгаалах нөхөн сэргээх	5,000.0	4,954.5	45.5	99
11	Хур хог хаягдал орчны бохирдол цэвэрлэх	200.0	200.0		100
12	Улсын их баяр наадам	4,000.0	4,000.0		100
13	Ахмадын сан	2,600.0	2,100.0	500.0	80.7
	Нийт дүн	469,778.2	457,641.3	12,136.9	97.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 106,507.1 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 6,340.0 мянга, нийт 112,847.1 мянган төгрөг бүрдүүлжээ.

Үүнээс Тээвэр шатахууны зардал 1,120.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 1,600.0 мянга, урсгал засварт 1,500.0 мянга, бусад хөрөнгийн зардалд 103,785.1 мянга, нийт 108,005.1 мянган төгрөг зарцуулсан байна. Нэмэлт санхүүжилтийн данснаас 4,842.0 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өмнөговь сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Намжил гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Өмнөговь сумын Засаг даргын тамгын газар нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 7,032.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 928,943.1 мянган төгрөгийн 1.0 хувь буюу 9,289.4 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 7,431.5 мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Өмнөговь сумын Засаг даргын тамгын газрын хувьд хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд биет горим сорилыг хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно. /АБ-4/

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа байршуулсан 149 мэдээлэл, байршуулах хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Өмнөговь сумын Засаг даргын тамгын газар нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Өмнөговь сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 3,500.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоосныг хэрэгжүүлэн биелэлтийг ирүүлсэн байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд “Шинэ хөдөө Увс” төслийн шугамаар ирсэн “Сэлэнгийн халзан-Герефорд” үүлдрийн 7,994.7 мянган төгрөгийн 2 ширхэг өсвөр насны бух, 3,000.0 мянган төгрөгийн 10 ширхэг Баяд үйлдвэрийн хуц, 750.0 мянган төгрөгийн 3 ширхэг Өлгийн улаан ухан, нийт 11,744.7 мянган төгрөгийн мал амьтад дансанд бүртгэсэн байна. Тухайн мал амьтныг гэрээ байгуулан иргэдэд эзэмшүүлж байх бөгөөд дараагийн аудитын хүрээнд ашиглалт, гэрээний үр дүнг шалгах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЫ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

/М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

/Л.НАМЖИЛ/

2023 оны 02 дугаар сарын 15-ны өдөр